



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 273

Улаанбаатар хот

“Харилцаа холбооны зохицуулах хорооны 2026 оны
үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого, зардлын төлөвлөгөө,
2027-2028 оны төсвийн төсөөлөл”-ийг
батлах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.16 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 268 тоот тогтоолоор баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г энэхүү тогтоолын Нэгдүгээр, “ХХЗХ-ны 2026 оны орлогын төлөвлөгөө”-г Хоёрдугаар, “ХХЗХ-ны 2026 оны зардлын төлөвлөгөө”-г Гуравдугаар, “ХХЗХ-ны 2026 оны хөрөнгө оруулалтын зардал”-ыг Дөрөвдүгээр, “ХХЗХ-ны 2026 оны хөтөлбөр, арга хэмжээний зардал”-ыг Тавдугаар, “ХХЗХ-ны 2026 оны үйл ажиллагааны зардал”-ыг Зургаадугаар, “ХХЗХ-ны 2027-2028 оны төсвийн төсөөлөл”-ийг Долоодугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар баталсан Хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, батлагдсан зардал, төсвийг зориулалтын дагуу зарцуулан тухай бүр гүйцэтгэлийг тайлагнан ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮН

9069314-5 05130372

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР